



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 94

Эрдэнэт

Г Хурлын байгууллагын тогтоол, шийдвэрийн
хэрэгжилтийг хангах талаар авах
арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын бодлого, шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг боловсронгуй болгох, эрчимжүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

2. Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга М.Жанболатад ДААЛГАХ нь:

2.1. Аймгийн ИТХ-аас батлагдан гарч байгаа тогтоол шийдвэр, хугацаатай хариутай албан даалгавар, албан бичгийн хяналтыг нэгтгэн зангидах, байгууллагуудын хяналт хариуцсан ажилтан нэг бүртэй нягт уялдаатай ажиллаж, арга зүйн зөвлөмжөөр хангах, ажлын уялдаа холбоог сайжруулах.

2.2. Аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын тогтоол, шийдвэрийн биелэлтийн явц, түүний үр дүнг мэдээлдэг арга хэлбэрийг боловсронгуй болгох, эргэх холбоог сайжруулах.

2.3. Аймгийн хэмжээнд засаг захиргаа, төрийн үйлчилгээний байгууллага, улсын болон орон нутгийн өмчит компаниудад аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэртэй холбогдсон бүрдүүлж, баяжуулж, ашиглаж байх мэдээллийн сантай болгох, түүнд хамаарах мэдээллийн нэр төрөл, хамрах хүрээ, агуулгаар нь баяжилтыг тухай бүр хийлгэж хэвшүүлэх.

2.4. Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн биелэлтийг хагас болон бүтэн жилээр гарган жил бүрийн 07 дугаар сарын 25, 12 дугаар сарын 25-ны дотор Ажлын албанд ирүүлэх.

3. Аймгийн засаг захиргаа, төрийн үйлчилгээний байгууллага, улсын болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт ДААЛГАХ нь:

3.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлтийг байгууллагын хэмжээнд дарга биечлэн хариуцаж, хугацаанд нь хүргүүлдэг байх.

3.2. Байгууллага бүр хурлын байгууллагын тогтоол шийдвэрийг тодорхой нэг ажилтанд хавсран хариуцуулах.

C: / Togtool / -A4 doc

0010286

3.2.Байгууллага бүр хурлын байгууллагын тогтоол шийдвэрийг тодорхой нэг ажилтанд хавсран хариуцуулах.

3.3.Тухайн байгууллагаас хариуцан хэрэгжүүлэх хурлын байгууллагын тогтоол шийдвэрийн холбогдох зүйл заалт хэрэгжээгүй тохиолдолд түүний шалтгааныг тодорхой цаг хугацаанд нь гаргаж Ажлын албан ирүүлдэг байх.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилт, явц байдлын талаар жил бүрийн I улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж байхыг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст үүрэг болгосугай.

5. Тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцох стандарт гаргаж, мөрдүүлэхийг Ажлын албаны дарга Д.Эрдэнэцэцэгт даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА